



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 613

Улаанбаатар хот

Автомашины тоо төрөл тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, харьяа байгууллагын үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлайд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2. Албан хэрэгцээнээс илүү гарсан, үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ шаардлага хангахгүй байгаа автомашиныг данснаас хасах, хэрэгцээт байгууллагад шилжүүлэх саналаа ирүүлэх;

2.3. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.4. Арга хэмжээний биелэлтийн хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
13.10.2024
28-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын... өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗАР БОЛОН ХАРЬЯА
БАЙГУУЛЛАГУУДЫН ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ АВТОМАШИНЫ
АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

Д/д	Байгууллагын нэр	Үндсэн ангилал	Төрөл	Тоо
1	Газар зохион байгуулалт, геолези, зураг зүйн ерөнхий газар	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	3
			Хот доторх ажлын суудлын автомашин /жижиг/	1
2	Архангай аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ , Суудлын автомашин /жижиг/	2
3	Баян-Өлгий аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ , Суудлын автомашин /жижиг/	2
4	Баянхонгор аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ , Суудлын автомашин /жижиг/	2
5	Булган аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ , Суудлын автомашин /жижиг/	2
6	Говь-Алтай аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ , Суудлын автомашин /жижиг/	2
7	Говьсүмбэр аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/	1
8	Дархан-Уул аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
9	Дорноговь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
10	Дорнод аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
11	Дундговь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
12	Завхан аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2

13	Орхон аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Үйлчилгээний автомашин	Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
14	Өвөрхангай аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
15	Өмнөговь аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/ 2, Суудлын автомашин /жижиг/ 1	3
16	Сүхбаатар аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
17	Сэлэнгэ аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
18	Төв аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
19	Увс аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
20	Ховд аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
21	Хөвсгөл аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
22	Хэнтий аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар		Туулах чадвар сайтай автомашин /жип төрлийн/, Суудлын автомашин /жижиг/	2
Нийт автомашин			46	